

БАЙГАЛЬ ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

*ДХИС-ийн Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)
цагдаагийн ахмад И.Ургамал
urgamalivanov@gmail.com*

Хураангуй. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистемийг тусгай хамгаалалтад авч, унаган байгалийг хамгаална гэж заасанчлан Монгол Улс ирээдүйн хөгжлийнхөө алсын харааг экологи, байгаль орчинд ээлтэй байхаар томъёолж хуульчилж байгаа билээ. Гэвч хууль тогтоомжийн үл нийцэл, хэрэгжилтийн дутмаг байдал өнөөг хүртэл байсаар байгаа бөгөөд энэхүү өгүүлээр тус асуудалд хууль эрх зүйн үүднээс үнэлэлт, дүгнэлт өгөхийг хичээлээ.

Түлхүүр үг: *Экологи, тэнцвэрт байдал, хүний эрх, хууль зүйн хамгаалалт, зөрчил, гэмт хэрэг.*

Оршил.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго 6-д Ногоон хөгжлийг томъёолсон бөгөөд байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна, **Зорилт 6.1-д** Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална гэж заасан.

Мөн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.2-т Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал ... экологийн тэнцвэрт хөгжил багтана гэж;

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна гэж тус тус заасан.

Мөн 2016 оны 1 сарын 1-нээс дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн тогтвортой хөгжлийн баримт бичгийг нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн үндсэн гурван тулгуурт суурилан боловсруулсан байдаг. Үүнээс дүгнэвэл байгаль орчин, экологийн асуудал нь хүний оршин байх, аюулгүй амьдрахын гол тулгуур хүчин зүйл болох нь харагдаж байна.

Нэг. Монгол Улсын байгаль орчныг хамгаалах эрх зүйн зохицуулалт.

Монгол Улсад байгаль орчны чиглэлээр 33 хууль, нэгдэн орсон буюу соёрхон баталсан олон улсын 14 гэрээ, конвенц хүчин төгөлдөр үйлчилж байна. Эдгээр хуулийг ерөнхий агуулгын хувьд:

1. Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн;
2. Уул уурхайн салбарын хуулиуд;
3. Байгаль орчны хяналтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн процедурын шинжтэй хуулиуд;

4. Татвар (албан татвар, төлбөр, хураамж) хураахад чиглэсэн хуулиуд хэмээн дөрвөн хэсэгт ангилж болно⁴. Үүнээс гадна байгаль орчны гол эрх зүйн хамгаалалт бол Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль мөн юм. Хэдийгээр эрх зүйн орчин бүрэлдэн тогтсон боловч хууль хоорондын зохицол, хэрэгжилтийн асуудал өнөөг хүртэл тулгамдсан асуудал хэвээр байна.

Мөн Монгол улсын Үндсэн хуульд заасанчлан “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх”-эд чиглэгдэх учиртай.

Энэхүү зорилгыг бүрэн хангаж чадаж буй эсэх нь өнөөдөр тулгамдсан асуудлын нэг бөгөөд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, түүнчлэн зөрчлийн хуулийн заалтууд өөр хоорондоо зөрчилтэй, эрүүгийн хуулиар хамгаалагдвал зохих байгалийн үнэ цэнэтэй объект болох ус, ус бохирдуулахтай холбогдсон үйлдлийг эрүүгийн хуулиас гадуур шийдэж байгаад үнэлэлт дүгнэл өгөхөд чиглэгдлээ.

Тодруулбал, Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн олон гэмт хэргүүд нь зөрчлийн хуульд заасан зөрчлийн шинжтэй агуулгын давхардал үүсгэснээр энэ төрлийн гэмт хэргийн тоо буурч харин зөрчлийн тоо эрс өссөн юм.

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт гарсан энэ төрлийн зөрчлийн дийлэнх буюу 98 хувийг Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчлийн тоо эзэлж, сүүлийн 3 жилд дунджаар энэ тухай гомдол, мэдээлэл 176 бүртгэгдсэний 96 хувьд зөрчлийг шалгаж тогтоон, холбогдогч нарт шийтгэлийн хуудсаар шийтгэл оногдуулсны 45 хувьд нь хуулийн этгээдэд, 55 хувьд хүнд, нийтдээ 165.093.020 төгрөгийн торгох шийтгэл оногдуулсныг төлж барагдуулсан байна. Дээрх зөрчлүүдийн 49 хувийг Зөрчлийн тухай хуульд заасан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих”, 27 хувийг “Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах”, 16 хувь нь “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих”, үлдсэн хувийг “Агаарын тухай, Ойн тухай, Амьтны тухай, Усны тухай хуулиудыг зөрчих” зөрчлийн тоо эзэлж байна.

Харин хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг нь нийт байгаль, хүрээлэн буй орчны гэмт хэргийн 44.5 хувь, хууль бусаар мод бэлтгэх нь 36.1 хувь, хууль бусаар ан агнах 11.7 хувь тус тус эзэлж жил бүр тогтмол үйлдэгдэж нэмэгдсээр байна⁵. Мөн Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийхэд ихэнх тохиолдолд торгох ял оногдуулдаг ба байгалийн объектуудын экологи, эдийн засгийн үнэлгээ өндөр байдаг учраас гэмт хэргийн улмаас учруулсан хохирлын хэмжээ их гарч ингэснээр торгох ялын үр нөлөө буурах хандлагатай байгаа юм. Өөрөөр хэлбэл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлж чадахгүй хүн торгуулийг төлж чадах эсэх нь эргэлзээтэй. Түүнчлэн хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж байгаа тохиолдол нилээдгүй байгаа нь шүүхийн шийтгэх тогтоолд хийсэн дүн шинжилгээгээр тогтоогдлоо⁶.

Байгаль орчныг бохирдуулах гэмт хэргийн дотор тулгамдаж буй гол асуудал нь усны бохирдол, 2020 оны усны тооллогын дүнгээр 116 гол горхи, 381 булаг шанд, 180 нуур

⁴ Уул уурхайн салбар дахь БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ШИНЖИЛГЭЭ. 2018 он

⁵ Баянгол дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор, хууль цаазын зөвлөх Эрдэнийн Болор-Эрдэнийн ярилагаас, <https://www.arslan.mn/social/news/633574.shtml>.

⁶ <https://legaldata.mn/shiidver/huraangui>

тойром, 5 рашаан ширгэсэн дүн гарсан байна. ⁷ Энэ нь мэдээж дийлэнх нь хүний, хуулийн этгээдийн хууль бус үйлдэл, үйл ажиллагаатай холбоотой. Гэтэл энэ үйлдлийг эрүүгийн хуулийн хамгаалалтаас гадна үлдээсэн, зөвхөн зөрчилд хариуцлага тооцож торгох байдлаар хязгаарлаж байгаа нь дээрх байгалийн тэнцэл алдагдахад хүргэх нөхцлүүдийн нэг гэж харж байна.

Хоёр. Байгаль орчны эрх зүйн хамгаалалтын хийдэл, зөрчил.

Ийнхүү Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт зөрчилдөөнтэй, хэргийн зүйлчлэл хийхэд хүндрэл учруулж, хуулийн хэрэгжилт, хэрэглээний явцад онол, арга зүйн болон бодлого, зохицуулалтын алдаа, хийдэл бүхий асуудлууд үүсэж улмаар хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх, нөгөө талаас ял завшуулах боломжийг олгож эрүүгийн эрх зүйн зохицуулалтын ээдрээ төвөгтэй байдал нь байгалын тэнцэл алдагдах, хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэлт хийхэд хүрч байна.

Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн давхцал, хийдэлтэй зарим зүйл, заалтыг дурдвал:

1. Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг (ЭХТА.24.6)

Энэ гэмт хэргийн объект нь мод бэлтгэх талаар тогтоосон журам, Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу ойн нөөц нь төрийн өмч мөн бөгөөд гагцхүү ард түмний мэдэлд байх (Ойн тухай хууль.4.1) утгаараа төрийн өмчлөх эрхэд халдсан давхар объекттой гэмт хэрэг юм.

Зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан нь энэ гэмт хэргийн объектив талыг бүрдүүлнэ.

Субъектив тал нь санаатай гэм буруугаар илэрнэ.

Субъект нь нийтлэг субъект байх ба хүндрүүлэх нөхцөлд хуулийн этгээдийг субъектээр тооцсон.

Зөрчлийн хуулийн 7.9. 11.”Гэрээ байгуулахгүйгээр ойгоос мод бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчин үйл ажиллагаа явуулсан бол...” зөрчилд тооцож шийтгэл хүлээлгэхээр заажээ.

Ойн тухай хуулийн 33.1.”Ойн санг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллага сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн ойн анги (байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан) -тай мод бэлтгэх гэрээ байгуулна”, мөн хуулийн 34.1.”Энэ хуулийн 32.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон хэмжээнд багтаан ойн анги /байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан/ иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагад мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгоно”, мөн хуулийн 38.1.”Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн дагалт баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг тухайн ойн анги /байхгүй бол тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч/ олгоно” гэж заасны дагуу ойгоос мод бэлтгэх, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн нь ЭХТА-н 24.6 дахь хэсэгт заасан гэмт хэргийн объектив талын заавал байх шинж болно.

⁷ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасаны мэдээлэл. 2020 он.

Энэ нь мөн зөрчлийн хуулийн 7.9. 11 “Гэрээ байгуулахгүйгээр ойгоос мод бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчин үйл ажиллагаа явуулсан” гэх зөрчлийн объектив шинжийн үйлдлийг хангаж буй нь дээрхийн адил тухайн тохиолдолд (ЭХТА 24.6) гэмт хэрэг гэж үзэх үү эсхүл зөрчилд (ЗТХ 7.9. 11)-ээр хариуцлага хүлээлгэх эсэх асуудал нь эргэлзээтэй, “коллизи” үүсгэсэн асуудал болж байна.

2. Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэрэг/ЭХТА.24.8/.

Энэ гэмт хэргийн объект нь ховор, нэн ховор байгалийн ургамлыг бэлтгэх талаар тогтоосон журам, нөгөө талаас төрийн өмчийн халдашгүй байдал давхар объект нь болно.

Объектив тал нь зохих зөвшөөрөлгүйгээр, хуульд зааснаас өөр зорилгоор нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтэнийг түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан хууль бус үйлдлээр илэрнэ.

Субъектив тал нь санаатай гэм буруугийн хэлбэртэй.

Субъект нь нийтлэг субъект байх ба хүндрүүлэх нөхцөлд хуулийн этгээдийг субъектээр тооцсон.

Зөрчлийн хуулийн 7.7 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хууль зөрчих.

1. Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж:

1.1. байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд;... түүсэн, бэлтгэсэн, худалдсан бол гэж заасан нь ЭХТА-н 24.8 дахь хэсэгт заасан гэмт хэргийн объектив шинжтэй яахын аргагүй давхцаж байгаа нь ихэнх тохиолдолд зөрчилд шийтгэл хүлээлгэж байна.

4. Байгалийн тэнцэл алдагдуулах гэмт хэрэг /ЭХТА.24.9/

Амьтан, ургамлын зүйлийг зөвшөөрөлгүйгээр гэмтээсэн, устгасан, газар, газрын хэвлий, агаар мандал, усны нөөцийг хордуулсан, бусад хэлбэрээр экологийн тогтолцоог алдагдуулсныг Байгалийн тэнцэл алдагдуулах гэмт хэрэг гэнэ.

Объект нь байгаль болон хүний амьдрах эрүүл аюулгүй орчин

Объектив тал нь байгалийн тэнцэл алдагдуулсан хууль бус үйлдлээр илэрнэ. Энэхүү хууль бус үйлдэл нь амьтан, ургамлыг зөвшөөрөлгүй гэмтээсэн, устгасан, газар, газрын хэвлий, агаар мандал, усны нөөцийг хордуулж улмаар экологийн тэнцвэртэй байдлыг алдагдуулснаар илрэх юм.

Хуульчлагдсан диспозицид амьтан, ургамлын зүйлийг зөвшөөрөлгүйгээр гэмтээсэн, устгасан, газар, газрын хэвлий, агаар мандал, усны нөөцийг хордуулсан гэх үйлдлүүд тусдаа бие даасан үйлдэл, эдгээрээс гадна өөр бусад хэлбэрээр экологийн тогтолцоог алдагдуулсан үйлдэл байхаар тусгажээ. Тэгэхээр дуобдсан үйлдлүүдийн аль нэгийг хийснээр төгс үйлдэгдсэн гэмт хэрэг болох бөгөөд үйлдлийн эцэст экологийн тогтолцоо “алдагдсан” байхыг шаардахгүй хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг болно.

Субъектив тал нь санаатай гэм буруугаар илэрнэ.

Субъект нь нийтлэг субъект, хүндрүүлэх нөхцөлд хуулийн этгээд гэмт хэргийн субъект болох юм.

Зөрчлийн хуулийн холбогдох заалтууд:

а/Зөрчлийн хуулийн 7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих

1. Хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг:

1.1.ашигласан;

1.2.барьсан;

1.3.агнасан бол гэх заалт нь ЭХТА-н 24.9.1 дэх хэсэгт заасан “...амьтан...зөвшөөрөлгүйгээр устгасан, гэмтээсэн...” гэх заалттай адил хуульчлагдсан байх байгаа нь хэргийн зүйлчлэл хийхэд хүндрэл учруулж байна.

Энэ тохиолдолд ихэнхдээ зөрчлийн хуулиар шийтгэл хүлээлгэж байна. Учир нь ЭХТА-н 24.9 дэх хэсэгт заасан гэмт хэргийн объектив шинж маш ерөнхий байдлаар хуульчлагдсан, өөрөөр хэлбэл дурьдсан үйлдлүүдийг хийснээр “экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүргэсэн” гэх нөхцлийг дэлгэрүүлж хуульчлах зайлшгүй шаардлагатай байгааг анхаарах хэрэгтэй юм.

б/. Зөрчлийн хуулийн 7.7 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хууль зөрчих

1.Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж:

1.1.байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд;

1.2.элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор түүсэн, бэлтгэсэн гэх заалт ЭХТА-н 24.9.1 дэх хэсэгт заасан “...ургамал...зөвшөөрөлгүйгээр устгасан, гэмтээсэн...” гэсэнтэй мөн л давхцаж байгааг дээрх байдлаар тайлбар хийхэд хүргэж байна.

Хэргийн зүйлчлэл хийхэд мэдээж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 1.15 дахь хэсэгт заасан “гэм буруугийн зарчим”-д тулгуурлан зөрчлийн хуулиар шийтгэл хүлээлгэх боломжтой.

в/.Уг гэмт хэргийн объектив үйлдэл болох “...газар, газрын хэвлийг хордуулсан...” нь Зөрчлийн хуулийн 7.10 дугаар зүйл.Газрын хэвлийн тухай хууль зөрчихтэй холбоотой заалт түүний дотор 7.10.8 дахь хэсэгт “Ашигт малтмалын ордыг гэмтээж сүйтгэсэн, баялаг хэсгийг нь сорчлон олборлосон, эсхүл ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн, олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн бол...” гэх заалттай,

г/.Уг гэмт хэргийн “агаар мандал... хордуулсан...” гэх үйлдэл нь Зөрчлийн хуулийн 7.4 дүгээр зүйл.Агаарын тухай хууль зөрчих заалт бүхэлдээ,

д/. Тухайн гэмт хэргийн “...усны нөөцийг...хордуулсан, экологийн тогтолцоог алдагдуулсан...” гэх үйлдэл Зөрчлийн хуулийн 7.15 дугаар зүйл.”Усны тухай хууль зөрчих” заалт бүхэлдээ тус тус тухайн гэмт хэрэгтэй давхардан хуульчлагдсан байна. Энэ тохиолдолд дээр дурдсаны дагуу зөрчилд шийтгэл хүлээлгэх байдлаар шийдвэрлэж байгаа бөгөөд практикт ЭХТА-н 24.9 дэх хэсэгт зааснаар зүйлчилж ял оногдуулсан кейс байхгүй байна.

Иймээс “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг” ЭХТА-н 24 дүгээр бүлэгт нэмэлт өөрчлөлт яаралтай оруулах шаардлагатай байна. Дээрх байгаль орчны эсрэг, байгалын тэнцэл алдагдуулсан үйлдлүүдийг Эрүүгийн хуулиар хамгаалсанаар хүний эрүүл аюулгүй

орчинд амьрах, байгалын тэнцэл алдагдуулахаас хамгаалагдах эрх хэрэгжих нэг суурь нөхцөл болох юм.

ДҮГНЭЛТ

Манай улсад байгаль орчны талаар эрх зүйн орчин бүрэлдэн тогтсон боловч хууль хоорондын зохицол, хэрэгжилтийн асуудал өнөөг хүртэл тулгамдсан асуудал хэвээр байна. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг нь байгаль орчин, хүний эрүүл аюулгүй орчин түүнчлэн төрийн нийтийн өмчид халдсан нийгэмд аюултай үлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэж өргөн хүрээнд тодорхойлох боломжтой. Өөрөөр хэлбэл энэхүү бүлгийн гэмт хэргийн объект нь байгаль орчин болон хүний амьдралын эрүүл аюулгүй орчин, нөгөө талаас Монгол улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1.Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.

Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн, нийтийн өмч мөн гэснээс төрийн, нийтийн өмчлөх эрх уг бүлгийн гэмт хэргийн объект болно гэж үзэж байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн олон зүйл хэсэг нь зөрчлийн хуульд тусгагдсан зөрчлийн шинжтэй агуулгын давхцал үүсгэж улмаар хэргийн зүйлчлэл хийж ял оногдуулахад хүндрэл бэрхшээл учруулж байгаа нь харагдаж байна. Энэ нь ял завшуулах эсхүл хүний эрхийг зөрчих явдлыг өөгшүүлэх бөгөөд гэмт хэргийн болон зөрчлийн давхардсан үйлдлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 1.15 дахь хэсэгт заасан “Гэм буруугүйд тооцох” зарчмын хүрээнд “...эрүүгийн хууль болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ” гэснийг баримтлах боловч үр дагавар нь гэмт хэргийг зөрчил гэж зүйлчлэх эрсдэл учруулж байгаа юм. Иймээс Эрүүгийн хуулийн 24-р бүлэгт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатайг харуулж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Эрүүгийн хууль 2015 он
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль 2017 он
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
5. Зөрчлийн хууль 2017 он
6. Агаарын тухай хууль 2012 он
7. Амьтны тухай хууль 2012
8. Байгалийн ургалмлын тухай хууль 1995 он
9. Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995 он
10. Усны тухай хууль 2012 он
11. Газрын тухай хууль 2002 он
12. Газрын хэвлийн тухай хууль 1988 он
13. Ашигт малтмалын тухай хууль 2006 он
14. Ойн тухай хууль 2012 он
15. Цөмийн энергийн тухай хууль 2009 он
16. Химийн хортой болон аюултай бодисын тухай хууль 2006 он

Хоёр. Ном, сурах бичиг

17. С.Нарангэрэл.Монгол улсын Эрүүгийн эрх зүй.Ерөнхий анги.УБ.1999

18. С.Нарангэрэл. Монгол улсын Эрүүгийн эрх зүй.Тусгай анги.УБ.1995
19. С.Жанцан.Монгол улсын Эрүүгийн эрх зүйн онол.1 боть (Гэмт хэргийн сургааль).УБ.2009
20. Д.Баярсайхан. Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн процессын шинэтгэлийн асуудлууд.УБ.2019

Дөрөв.Статистик, тоо баримтын судалгаа

21. Цагдаагийн байгууллагын тоо баримт 2018-2020 он
22. Прокурорын байгууллагын зөрчлийн талаарх тоо баримт 2018-2020 он
23. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан тоон судалгаа/ЭХТА-н 24 дүгээр бүлэг.Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг/ 2018-2020 он